



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2017 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 02

Арвайхээр

**Төсвийн орлого нэмэгдүүлэх, татвар хураалтын
ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга
хэмжээний тухай**

Аймгийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 11351 хүнд 537436000 төгрөгийн бэлэн бус торгууль оногдуулсанаас аймгийн төрийн санд 310881225 төгрөгийн орлого төвлөрч 226554775 төгрөг төлөгдөөгүй байна.

Иймд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийн торгуулийн орлого хураалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

1. Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж болон бусад орлогыг ард иргэдэд сурталчлах албан татварын хууль, хувь хэмжээг таниулах ажлыг зохион байгуулах, татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, татвар хураалтын ажлыг эрчимжүүлэх Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд)-д

2. Өвөрхангай аймгийн тодорхой цэгүүдэд хамтарсан ажлын хэсэг гаргаж авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн зам ашигласны хураамж, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийн торгуулийн орлогоо хуулийн хугацаанд төлөөгүй иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг газар дээр нь арилгаж, орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд) нарт

3. Албан даалгаврын дагуу арга хэмжээ авч, төсөвт төвлөрсөн орлогын дүн мэдээг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Татварын хэлтэс (Н.Эрдэнэсүвд), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

02 - -0003